

ХОЁРДУГААР АЖЛЫН ХЭСЭГ-3 дугаар хуралдаан

2015 оны 5 дугаар сарын 21-ний 14,00 цагт Уул уурхайн яамны 3 дугаар давхарын Хурлын танхимд болж, 15,45 цагт төгсөв.

Ирц:

	Албан тушаал	Нэр	Ирсэн/Ирээгүй бол тайлбар
1	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны ХБОНГ-ын ахлах мэргэжилтэн	Б.Саран	Саран, Тулга хоёул ирэв.
2	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын ГУУ-ын улсын ахлах байцаагч	Ц. Мөнхцэцэг	Хурал давхацсан.
3	Уул уурхайн яамны СБТГ-ын мэргэжилтэн	Т.Зууннаст	Ирсэн.
4	Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч	Н.Алгаа	Ирсэн.
5	Монполимет ХХК-ийн гүйцэтгэх захирал	С.Энхтуяа	Ирсэн.
6	Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын ТУЗ-ын гишүүн	Л.Долгормаа	Ирсэн.
7	Хөвсгөл далайн эзэд ТББ-ын тэргүүн	Б.Баярмаа	Ирсэн.
8	Байгаль орчны аудитын холбооны Удирдах зөвлөлийн дарга	Д.Энхээ	Хөдөө, Төв аймагт
9	МБОИЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн	Б.Батболд	Хөдөө, Баянхонгор аймагт
10	Монголын байгаль орчны төлөөх хуульчдын холбоо	Ц.Туяацэцэг	Хөдөө, Дорноговь аймагт
11	ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч	Ш.Цолмон	Ирсэн.

Ш.Цолмон- 11 гишүүн ирэхээс 8 хүн ирсэн нь хурлаа хийх боломжтой болсныг мэдэгдэж, өмнөх хурлын шийдвэрүүдийг танилцуулсан байна.

Л.Долгормаа- Байгаль орчины нөхөн төлбөрийн барьцааны 50 хувийг тусгай дансанд байршуулдаг хэмжээ янз бүр, хэтэрхий бага, түүнийгээ дагаад байгаль орчины үнэлгээ шударга эсэхэд ОУИТБС-ын хүрээнд хийгдсэн судалгаагаар эргэлзэж байгаа билээ. Эдгээр хөрөнгийг БОЯ яаж хянадаг, Яамнаас буцаан олгодог эсэх, барьцаа хаана байна гээд олон асуулт гарч байгаа юм.

М.Тулга- Байгаль орчины нөхөн сэргээлтийн асуудлыг зохицуулахдаа нарийвчилсан төлөвлөгөөг 5 жилийн хугацаатай батлуулж, түүнийгээ 5 жилд хувааж, жил бүрийн нөхөн сэргээлтийн зардлын 50 хувийг тусгай дансанд байршуулдаг юм. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг орон нутагт хянадаг юм.

С.Энхтуяа- Орон нутагт нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авдаг бөгөөд бичиг өгдөг. Тэр бичгийн дараагийн жилийн төлөвлөгөөг батлуулдаг юм.

М.Тулга- Та бүгдэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сангийн <http://www.eic.mn/eia/> гэдэг холбоосыг хүргүүлсэн билээ. Уг холбоосыг ашиглан мэдээлэл авч

болно шүү.Тусгай данс гэдэг нь Сангийн яаман дээр байрлах Төрийн сан, банк л гэсэн үг. Хүү боддоггүй банк.

Б.Саран- Хууль гарч, 2007 оноос хойш 50 хувийн барьцаа байршуулж эхлэсэн, одоо 9,4 тэрбум төгрөг болов. Энэ мөнгөний тулгалтыг Сангийн яамтай жил бүр хийж, яг таарч явдаг юм. Тэгэхдээ энэ бол ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой урьдчилгаа, харин хайгуулын барьцааг орон нутагт төлдөг болохоор нэгтгэх асуудал хэцүү байдаг. Ер нь бидэнд байгаа мэдээллийг ашиглан судалгаа хийх бүрэн боломжтой. Тухайлбал, тасралтгүй барьцаалсан компани хэд, барьцааны хэмжээ их байна уу, бага байна уу гээд олон судалгаа хийж болно. Ганцхан судалгаа хийхэд шаардагдах хөрөнгөний асуудал шийдэгдэхгүй байгаа юм. Ерөнхийдөө компаниудын байдал муудаад л байна. Ялангуяа жижиг компаниудын үйл ажиллагаа их муудаж байгаа нь ажиглагдаж байна.

Н.Алгаа- 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн дагуу барьцаа төлбөрийн хувьд хайгуул нь орон нутагт, ашиглалт нь БОЯ дээр гэж хуваарилагдсан билээ. ОУИТУС- ын хүрээнд нөхөн сэргээлтийн зардлыг ил тод болгоход зөрүү их гарч байсан нь 2 өөр системийг тулган баталгаажуулж болдоггүй нь нотлогдож, барьцаа илүү тохиромжтой, бодитой гэдгийг ойлгож авсан юм. Гэсэн хэдий ч, барьцааны их, бага алин ч ил тод байдлын асуудал биш юм. Тийм учраас гарцаагүй шийдэх асуудлын нэг юм.

Хуралд ирсэн гишүүд саналаа солилцож, зөвлөлдсөний эцэст дараах асуудлаар тохиролцов.

Тохирсон нь:

1. Гишүүн Долгормаа, Баярмаа, Энхтуяа нар БОНХАЖЯ дээр ажиллаж, бүх материалуудтай танилцаж ямар хэмжээний судалгаа хийх, ямар дүгнэлт хийж болохыг тодорхойлон, 5 дугаар сарны 29- ны өдөр Ажлын хэсгээрээ эргэн цуглаж ярилцах, түүний үндсэн дээр 6 дугаар сарын 4- ний Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулга бэлдэх.
2. БОНХАЖЯ- наас 2007 оноос хойшхи материалуудыг саадгүй 5 дугаар сарын 22- ны дотор өгөх.
3. Шалгуур үзүүлэлтийн дагуу судалгааг дараах компаниудаар хийж, танилцуулга хийх хэвээрийг нотлов. Үүнд:
  - a. Арева- Батболд,
  - b. Петрочайне- Долгормаа,
  - c. Дунюань- Туяацэцэг,
  - d. Алтайн хүдэр- Туяацэцэг,
  - e. Монполимет-Энхтуяа,
  - f. Боржигоны тал-Баярмаа,
  - g. Магнай Трейд- Зууннаст,
  - h. Жи энд Юу Гоулд- Туяацэцэг,
  - i. Тэгш плант-Баярмаа,
  - j. Харанга ресурс-Туяацэцэг,
  - k. Таван толгой- Туяацэцэг.
  - l. Аспайер майнинг-ийн судалгааг Уул уурхайн ассоциац хийхээр тогтов.
4. Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн эрх зүйн зохицуулалтын судалгааг Туяацэцэг танилцуулна.